

ТАНИЛЦУУЛГА

*Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг
түр зогсоох тухай хуулийн төслийн талаар*

2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын 4 дүгээр хавсралтаар тус бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газраас боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хуулийн төслийн жагсаалтыг баталсан. Үүний дотор Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай хуулийн төслийг боловсруулж, 2022 оны 01 дүгээр сард багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан байна.

Төрийн хяналт шалгалтын улмаас хүнд суртал нэмэгдэж, бизнес эрхлэгчдэд дарамт учирч байна гэсэн ойлголт олон нийтийн дунд түгээмэл байгаа нь олон удаагийн судалгаа, тэдгээрээс гарсан дүгнэлтэд дурдагдсан байдаг. Мэргэжлийн хяналтын байгууллагын статистикаас үзэхэд 2020 онд 9903 аж ахуйн нэгжийн 9920 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс 62.2 хувь буюу жилд 6170 орчим объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн байна.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын улмаас эдийн засагт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэхэд төлөвлөгөөт хяналт шалгалтыг түр хугацаанд зогсоох нь бизнес эрхлэгчдэд эерэгээр нөлөөлөх ач холбогдолтой гэж үзэж байгаа тул энэхүү хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл нь 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал үйлчлэх юм. Эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх зорилгоор 3 жилийн хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийхгүй бөгөөд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээллээр, эсхүл эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан тохиолдолд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хэвийн хийхээр заасан.

Мөн хэрэв төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийхэд зөрчил илэрсэн бол тэргүүн ээлжинд зөвлөн туслах, сануулах шинжтэй албан шаардлага хүргүүлэхээр тусгасан. Түүнчлэн энэ хуулийн үйлчлэх хугацаа дууссан нь төрийн хяналт шалгалтыг нөхөж хийх үндэслэл болохгүй.

Харин энэ хуульд заасан төлөвлөгөөт хяналт шалгалт хийхгүй байх, үйл ажиллагааг шууд зогсоохоос бусад төрлийн зөрчилд тэргүүн ээлжид зөвлөн туслах, сануулах шинжтэй албан шаардлага хүргүүлэх тухай зохицуулалт нь Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, татвар, гааль, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгал, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан эрх бүхий байгууллагаас хийх хяналт шалгалтад хамаарахгүй.

Мөн энэ хууль нь төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийхийг зогсоохгүй.

Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай хуулийн төсөл батлагдсанаар энэ хуулийн үйлчлэх хугацаанд бизнес эрхлэгчид хяналт шалгалтын улмаас учирч буй дарамтыг хөнгөвчлөн, тэдгээрт мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлдэг хяналт шалгалтын эрх зүйн орчин бүрдэхэд тус нэмэр болно гэж үзэж байна.

Хяналт шалгалтын үр дүнд торгууль ногдуулах бус, эхлээд зөвлөн туслах шинжтэй албан шаардлага хүргүүлэх нь хяналт шалгалтын байгууллага иргэд, аж ахуйн нэгжид туслах, дэмжих чиг үүргийг хэрэгжүүлдэг болоход ач холбогдолтой гэж үзэж байна.

Түүнчлэн тус хуулийн төслийг Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын улмаас эдийн засагт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулах, даван туулах зорилгоор түр хугацаанд үйлчлэхээр боловсруулж байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.7-д Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн, олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлийн хугацаанд хууль санаачлагчаас тухайн нөхцөлийг арилгах, түүнийг даван туулахтай холбоотой санаачилсан хуулийн төсөлд Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1.2-12.1.6-д заасан аргачлал хамаарахгүй гэж заасны дагуу тус хуулийн төсөлд хуулийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаа, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх шаардлагагүй гэж үзлээ.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төсөвт шинээр нэмэгдэх зардал байхгүй.

Хуулийн төсөлд Сангийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Зам тээврийн хөгжлийн сайд, Эрчим хүчний сайд, Гадаад харилцааны сайд, Батлан хамгаалахын сайд, Барилга, хот байгуулалтын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Соёлын сайд нараас санал ирүүлсэн байна.